

БАТЛАВ.  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ЯАМНЫ ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА  
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

С.ТУНГАЛАГТАМИР

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ТУСЛАХ ТЕХНОЛОГИЙН МЭРГЭШСЭН АЖИЛТАН БЭЛТГЭХ ЦАХИМ  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

### **НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 26 дугаар зүйлд оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан сэргээн засах тусламж үйлчилгээнд хэрэглэх туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээмжтэй байлгах, тэдгээрийн зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхүүлэн дэмжих гэж тусгагдсан билээ<sup>1</sup>.

Монгол Улсын Засгийн газраас Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж буй “L3605/G9191-MON: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Архангай, Дорнод, Хөвсгөл, Ховд, Дундговь, Дархан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 216 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн орон нутаг дахь салбар төв байхаар баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн эрхлэх асуудлын хүрээнд орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах технологийн үйлчилгээг үзүүлэх тул олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, протез, ортопедийн туслах технологийн үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн ажилтныг бэлтгэх зэрэг шат дараалсан арга хэмжээг зохион байгуулж байна.

Туслах технологийн үйлчилгээ нь багийн гишүүд болон гурав дахь шатлалын лавлагаа төвүүдийн дэмжлэгтэйгээр туслах бүтээгдэхүүнийг сонгох, нийлүүлэх (захиалах, үйлдвэрлэх) сургах, дасан зохицуулах, хянах үйлчилгээг үзүүлэх юм. Энэхүү сургалт нь хоёр хэсгээс бүрдэх ба сургалтын нэгдүгээр хэсэг болох энэ удаагийн сургалт нь цахимаар зохион байгуулагдана. Сургалтын хоёрдугаар хэсэг нь 2022 оны намар танхимаар зохион байгуулагдана.

### **ХОЁР. ЗОРИЛГО**

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн орон нутаг дахь салбар зургаан төвийн туслах технологийн мэргэшсэн ажилтан бэлтгэх, техник, тоног төхөөрөмжийг ашиглах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд оршино.

<sup>1</sup> United Nations Convention on the Rights of Persons with Disabilities. (2006). Accessed 20.12.2021:<https://www.un.org/disabilities/documents/convention/convoptprot-e.pdf> P. 19.

## **ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ**

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
- Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
- “Эм си ди эс консалтанси” ХХК

## **ДӨРӨВ. САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА**

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “L3605/G9191-MON: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”

### **ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ:**

Архангай, Дорнод, Хөвсгөл, Ховд, Дундговь, Дархан аймагт байгуулж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн туслах технологийн ажилтнууд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ортопед, туслах хэрэгслийн ажилтан оролцоно. Сургалтын нэгдүгээр хэсэг болох суурь мэдлэг олгох цахим сургалт нь хөгжлийн бэрхшээл, сэргээн засах, туслах бүтээгдэхүүн, протез, ортозийн салбарт ажиллах сонирхолтой бүх хүмүүст нээлттэй байх болно.

### **ЗУРГАА. СУРГАЛТЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн
- Мэдээллийн технологи, инновац, дизайн чиглэлээр ажиллах хүсэл, сонирхолтой
- Техник технологийн чадвартай
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах сонирхолтой
- Эрүүл мэнд болон боловсролын чиглэлээр зэрэг, дипломтой байж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл гэр бүлийн гишүүдээс дээрх шаардлагыг хангаж байх

### **ДОЛОО. СУРГАЛТЫН НЭР, БАЙРШИЛ, ХУГАЦАА**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн туслах технологийн мэргэшсэн ажилтан бэлтгэх 36 цагийн сургалт 2022 оны 6 дугаар сарын 06-17-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдана.

### **НАЙМ. ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ХУРААНГУЙ АГУУЛГА**

№	Багшийн нэр	Сэдэв	Хугацаа / минут	Цаг
1	ХБХХЕГ-ын СЗСҮТ-ийн дарга С.Баярбат	Туслах технологийн ажилтан бэлтгэх	60	1*
2	Б.Чулуундолгор	Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар	90	1.5
3	Д.Тулгамаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэх туслах технологиудын тухай	120	2

4	Шэйла Пүрвэс, А.Балжинням	Туслах технологи ба сэргээн засахын багаар ажиллах арга	60	1*
5	Б.Золзаяа	Үйл ажиллагааны анатоми №1: Доод мөч болон цээж	180	3
6	Д.Батлхам	Үений хөдөлгөөний далайц, булчингийн хүч	90	1.5
7	Д.Батлхам	Биеийн байрлал, алхаа: ажиглах арга	90	1.5
8	Б.Золзаяа	Үйл ажиллагааны анатоми №2: Дээд мөч болон цээж	180	3
9	Наранзул Бямбаням	Хөгжлийн бэрхшээл №1: Мөчдийн тайралт	90	1.5
10	О.Гантулга	Протезын тухай	60	1
11	Б.Золзаяа	Үйл ажиллагааны анатоми №3: Тавхай, сарвуу	120	2
12	Д.Дулмаа	Ортозийн тухай	60	1*
13	Мөнгөнтуул Түвшинзаяа	Хөгжлийн бэрхшээл №2: Сколиоз болон хөлийн уртын зөрүү	90	1.5
14	С.Булганчимэг	Үйлчлүүлэгчийг үнэлгээ ба зорилго тодорхойлох	90	1.5
15	Д. Ганбат	Биомеханикийн үндэс	180	3
16	О.Гантулга	Хөгжлийн бэрхшээл №3: Нугасны гэмтэл болон үйл ажиллагааны ортоз	180	3
17	Д.Дулмаа	Ортопедийн гутал ба тавхайн ортоз	90	1.5*
18	А.Чинзориг	Өдөр тутам хэрэглэгдэх туслах бүтээгдэхүүн	90	1.5
19	М.Баялаг	Хөгжлийн бэрхшээл №4 Түнхний дутуу хөгжил, майга тавхай	120	2
20	Шэйла Пүрвэс А.Балжинням	Туслах технологийн олон улсын чиг хандлага	90	1.5*
	<b>Нийт</b>		<b>2160</b>	<b>Нийт 36</b>

\*Хичээлүүдийг СЗСҮТөв болон зөвлөхийн баг зохион байгуулах бөгөөд цагийн хөлс олгохгүй болно.

## ЕС. ХИЧЭЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛГА

### 1. Туслах технологийн ажилтан бэлтгэх сургалтын тухай Цахим сургалт

Хугацаа 60 минут

Багш: ХБХХЕГ-ын дарга

1. Туслах технологийн үндэсний төв болон хөгжлийн төвийн тухай
2. Хөгжлийн төвд хийгдэх туслах бүтээгдэхүүн, үйлчилгээний ач холбогдол
3. Хөгжлийн төвийн туслах технологийн ажилтны үүрэг, Монгол Улсын туслах технологийн салбарын хөгжил, боломж

## **2. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын тухай ойлголт**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Б.Чулуундолгор, Тэргэнцэртэй иргэдийн холбоо

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын хөгжлийн бэрхшээлийн тухай болон туслах технологитой салбарын үйл ажиллагаанд оролцогч талууд
2. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар болон орчны тохируулга, туслах технологийн ач холбогдол
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хууль, туслах бүтээгдэхүүний талаарх журам, зохицуулалтын ач холбогдол

Сургалтын материал: (1) PPT, (2) хуулийн линкнүүд

## **3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэх туслах технологиудын тухай**

Цахим сургалт

Хугацаа: 120 минут

Багш: Д.Тулгамаа, AIFO

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. ДЭМБ-ын нэн чухал туслах бүтээгдэхүүний жагсаалтад үндэслэн түгээмэл тохиолддог хөгжлийн бэрхшээлийн хүмүүсийн хэрэгцээг хангах олон төрлийн төхөөрөмжүүдийн тухай
2. Бусад туслах бүтээгдэхүүнээс ялгаатай байдлыг нь жишээ болгож протез ортозийн тухай танилцуулах
3. Хүмүүсийн хэрэгцээнд зориулсан төхөөрөмжүүдийн ангилал: түгээмэл хэрэглэдэг, арилжааны, захиалгаар, “энгийн бүтэцтэйгээс өндөр технологийн” гм

Сургалтын материал: (1) PPT; (2) ДЭМБ туслах бүтээгдэхүүний жагсаалт;

Даалгавар №1: Бидний хэрэглэдэг туслах бүтээгдэхүүнүүд

## **4. Туслах технологи ба сэргээн засахын багаар ажиллах арга**

Цахим сургалт

Хугацаа: 60 минут

Багш: Шэйла Пүрвэс/ А.Балжинням, Төслийн С2 багцын зөвлөхүүд

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олон мэргэжлийн багаар үзүүлэх тусламж үйлчилгээнд туслах бүтээгдэхүүний нийцлийг Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ын хүрээнд авч үзэж ойлгох
2. Туслах технологич болон сэргээн засахын багийн гишүүдийн гүйцэтгэл, зан төлөвийн үндэс суурь болсон үнэт зүйлс, итгэл үнэмшлийг тайлбарлах (ДЭМБ-ын сэргээн засахын чадамжид суурилсан хүрээ)

Сургалтын материал: (1) PPT

## **5. Үйл ажиллагааны анатоми №1: доод мөч & цээж**

Цахим сургалт

Хугацаа: 180 минут

Хуудас 4 / 9

Багш: Б.Золзаяа, Бие бялдар сэргээн засах судлалын Монголын нийгэмлэг

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Араг яс ашиглан хөл болон цээжний яс, үе, булчинг тодорхойлж, хүний бие дээр үзүүлэх
2. Хөдөлгөөн, мэдрэхүйн үйл ажиллагаанд мэдрэлжүүлэлтийн ач холбогдлыг ойлгох
3. Үений хөдөлгөөний далайц, булчингуудыг тодорхойлох (агонист, антагонист) (урьдчилсан байдлаар контрактурыг ойлгох)
4. Биеийн тэгш хэм, хөдөлгөөн хийхэд шаардагдах булчингийн уртын ач холбогдол (ялангуяа 2, 3 үе дамнасан булчингийн)

Сургалтын материал: (1) PPT;

Даалгавар №2: Доод мөчний үйл ажиллагаа, хөдөлгөөнд үнэлгээ дүгнэлт өгөх

#### **6. Үений хөдөлгөөний далайц, булчингийн хүч**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Д.Батлхам, АШУҮИС, Сувилахуйн сургууль, Хөдөлгөөн заслын тэнхим

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Үений хөдөлгөөний далайц, хэмжих арга, идэвхтэй болон идэвхгүй далайцын ач холбогдол, ялгаа
2. Суух, алхах, шатаар өгсөж уруудахад шаардлагатай үений далайцыг тодорхойлох
3. Булчингийн хүч үзэх арга, булчингийн хүчний 3-аас доош болон дээш оноог тайлбарлах

Сургалтын материал: (1) PPT; (2) видео бичлэг

#### **7. Биеийн байрлал, алхаа: ажиглах арга**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Д.Батлхам, АШУҮИС, Сувилахуйн сургууль, Хөдөлгөөн заслын тэнхим

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Биеийн үндсэн байрлал болон алхааны хэвийн үзүүлэлтүүдийг ажиглаж, үнэлэх
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд олонтоо тохиолдох алхааны эмгэг хэлбэрүүдийг тодорхойлох

Сургалтын материал: (1) PPT; (2) видео бичлэг

#### **8. Үйл ажиллагааны анатоми №2: дээд мөч & цээж**

Цахим сургалт

Хугацаа: 180 минут

Багш: Б.Золзаяа Бие бялдар сэргээн засах судлалын монголын нийгэмлэг

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Араг яс ашиглан гар болон цээжний яс, үе, булчинг тодорхойлж, хүний бие дээр үзүүлэх
2. Гарын үйл ажиллагаанд хөдөлгөөн, мэдрэхүйн мэдрэлжүүлэлтийн ач холбогдлыг ойлгох
3. Үений хөдөлгөөний далайц, булчингуудыг тодорхойлох (агонист, антагонист) (урьдчилсан байдлаар контрактурыг ойлгох)
4. Биеийн тэгш хэм, хөдөлгөөн хийхэд шаардагдах булчингийн уртын ач холбогдол (ялангуяа 2, 3 үе дамнасан булчин)

Сургалтын материал: (1) PPT;

Даалгавар #3: дээд мөчний үйл ажиллагаа, хөдөлгөөнд үнэлгээ дүгнэлт өгөх

### 9. Хөгжлийн бэрхшээл №1: Мөчдийн тайралт

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Наранзул, Бямбаням, АШУҮИС

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Мөч тайралтын түгээмэл шалтгаанууд (Монгол Улсад)
  2. Мөч тайралтын түвшнүүдийн нэршлүүд, мухар хэсгийн хэлбэрийн тухай
  3. Контрактур, булчингийн хатангиршил, мэдрэхүйн асуудлууд, өвдөлт, дурсах (фантом) өвдөлт, хаван, цоорол, биеийн жин нэмэгдэх/буурах гм тайлбарлах
- Сургалтын материал: (1) PPT; (2) видео бичлэг

### 10. Протезын тухай

Цахим сургалт

Хугацаа: 60 минут

Багш: О.Гантулга, Сэргээн засахын их эмч

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Дээд болон доод мөчдийн протезын бүрэлдэхүүн хэсэг, шинж байдал, нэр томъёо
  2. Шагай, өвдөг, түнхний үений протезын үйл ажиллагааг харуулах
  3. Дээд мөчдийн протезын сонголтууд, үндсэн үйл ажиллагаа (сарвуу, бугуй, тохой, мөр)
- Сургалтын материал: (1) PPT

### 11. Үйл ажиллагааны анатоми №3: тавхай, сарвуу

Цахим сургалт

Хугацаа: 120 минут

Багш: Б.Золзаяа, Бие бялдар сэргээн засах судлалын монголын нийгэмлэг

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Тавхай, сарвууны яс, булчин, мэдрэлүүд
2. Алхах үеийн тавхайн бүтцийг мэдэх ач холбогдол (хөлтэй хамааралтай), хөдөлгөөн алдагдахад гарах өөрчлөлт (Жишээ нь: өсгийн яс, эрхий хуруу томрох гм)
3. Түгээмэл тохиолдох тавхайн эмгэгүүд (пронаци эсвэл супинаци), мэдрэхүй алдагдах (чихрийн шижингийн невропати, хөлдөх) түүний үр дагавар
4. Сарвууны уян хатан, нарийн чимхлүүр хөдөлгөөний ач холбогдол болон бугуй/сарвуу/эрхий хурууны байрлал атгах үйл ажиллагаанд нөлөөлөх нь

Сургалтын материал: (1) PPT

### 12. Ортозийн тухай

Цахим сургалт

Хугацаа: 60 минут

Багш: Д.Дулмаа, Протез ортозын мастер технологич

Сургалтын зорилго: сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Ортозийн тодорхойлолт, эдгээрийн үйл ажиллагаа
2. Өргөн хэрэглэгддэг ортозийн нэршлүүд, нийтлэг хэрэглэгддэг ортозууд
3. Материал сонголт, тэдний шинж чанарууд

Сургалтын материал: (1) PPT

### 13. Хөгжлийн бэрхшээл №2: Сколиоз болон хөлний уртын зөрүү

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Мөнгөнтуул, Түвшинзаяа, АШУҮИС

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд та дараах зүйлийг сурах болно.

1. Нөхцөл байдал, асуудал, тавиланг тодорхойлох
2. Дасгал хөдөлгөөн, ортоз, мэс засал, протезын тусламжтай урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх

3. Нурууны бэхэлгээ (брэйс), зүүх хугацаа, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн боловсрол
4. Сколиозыг харж ажиглах, хэвтээ болон зогсоо байрлалд хөлийн уртыг хэмжих арга (видео бичлэг)

Сургалтын материал: (1) PPT; (2) видео

#### **14. Үйлчлүүлэгчийг үнэлгээ ба зорилго тодорхойлох**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: С.Булганчимэг, Хөдөлмөр засалч, АШУҮИС

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд та дараах зүйлийг сурах болно.

1. Үнэлгээний дэс дарааллыг тодорхойлох: эхний ярилцлага (ба ажиглах), асуумж болон бодит мэдээлэл, чадварыг үнэлэх (хүч), тулгарч буй асуудал, багийн зорилго болон зөвшилцөх
2. Үйлчлүүлэгчийн амьдарч буй орчинд тохируулан үйл ажиллагаа болон нийгмийн оролцоог сайжруулах зорилгыг тайлбарлах

Сургалтын материал: (1) PPT; (2) үнэлгээний хуудсын загвар

Даалгавар #4: үнэлгээний загвар хуудсыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцлага хийх (үйл ажиллагаа, нийгмийн оролцоо, гадаад орчны хүчин зүйлс дээр төвлөрөх)

#### **15. Био-механикийн үндэс**

Цахим сургалт

Хугацаа: 180 минут

Багш: Д. Ганбат, ШУТИС

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

Биомеханикийн зарчмууд (биеийн хөдөлгөөний тэнхлэгүүд, хөдөлгөөний чиглэл, гарын хөшүүрэг, дэлхийн татах хүч, протез, ортозтой хамаарал бүхий зогсох үеийн биеийн тэгш хэм, алхаа, 3 цэгт даралт, газрын үрэлцэх хүчний тухай)

Сургалтын материал: (1) PPT

#### **16. Хөгжлийн бэрхшээл №3; Нугасны гэмтэл болон үйл ажиллагааны ортоз**

Цахим сургалт

Хугацаа: 180 минут

Багш: О.Гантулга, Сэргээн засахын их эмч

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Нугасны гэмтлийн шалтгаан, гарах шинж, гэмтлийн түвшнээс хамаарч илрэх хөдөлгөөний болон мэдрэхүйн өөрчлөлт
2. Өвдөг-шагай-тавхайн ортоз, шагай-тавхайн ортоз, алхах хэрэгсэл, тэргэнцэр, суудлын олбогын гм хэрэгцээг тодорхойлох
3. Цоорол, түлэгдэл гэх мэтээс хэрхэн сэргийлэхийг тайлбарлах, арьсаа шалгах тухай
4. Давсаг, гэдэс, цусны эргэлт, бэлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх үндсэн асуудлууд (өдөр бүр тулгардаг боловч нүдэнд харагддаггүй)
5. Сэтгэл хөдлөл болон хэрхэн харилцах талаар ярилцах

#### **17. Ортопедийн гутал ба тавхайн ортоз**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Д.Дулмаа, Протез ортозын мастер технологич

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Одоо хэрэглэгдэж буй ортопедик гутлын төрлүүд, тавхайн ортозүүд
2. Гутал, түрүүтэй гутал, тавхайн ортоз хэрэглэх шалтгаанууд
3. Үнэлгээний хуудас ашиглан нэг нэгнийхээ гутал/ортозыг үнэлэх дадлага хийх

Сургалтын материал: (1) PPT; (2) тараах материал

### **18. Өдөр тутам хэрэглэгдэх туслах бүтээгдэхүүн**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: А.Чинзориг, Хөдөлгөөн засалч, СЗСҮТ

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Хүүхэд болон насанд хүрсэн хүний өдөр тутамд хэрэглэх шаардлагатай туслах бүтээгдэхүүнүүд
2. Түгээмэл хэрэглэгдэх нийтлэг загваруудын зарчим, өдөр тутамд хэрэглэгдэх жишээ
3. Өөртөө үйлчлэхэд туслах түгээмэл хэрэглэгддэг бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох, үзүүлж харуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэх жишээнүүд

Сургалтын материал: (1) PPT; (2) видео; (3) багаж төхөөрөмж хийх боломжтой бүтээгдэхүүн, материал

### **19. Хөгжлийн бэрхшээл №4; Түнхний дутуу хөгжил, майга тавхай**

Цахим сургалт

Хугацаа: 120 минут

Багш: М.Баялаг, ЭХЭМҮТ

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Түнхний дутуу хөгжил, майга тавхайг эрт илрүүлж, эмчлэхийн ач холбогдол
2. Түнхний дутуу хөгжлийн үед павликийн дөрөөвч хэрэглэхийн давуу болон сул талууд, ач холбогдлыг ойлгох, шинэ ортозийн төрлүүд
3. Майга тавхайн эмгэгийн үед хэрэглэх гутлын (abduction shoe brace) давуу болон сул талууд, ач холбогдол
4. Хүүхэд брэйсийг зөв өмсөх нь ямар ач холбогдолтойг эцэг эхэд тайлбарлах

Сургалтын материал: (1) PPT

### **20. Туслах технологийн олон улсын чиг хандлага**

Цахим сургалт

Хугацаа: 90 минут

Багш: Шэйла Пүрвэс/ А.Балжинням, Төслийн С2 багцын зөвлөхүүд

Сургалтын зорилго: Сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна.

1. Туслах технологийн тухай дэлхийн тайлан (2022 оны 5 сард хэвлэгдсэн) ба туслах технологийн цар хүрээ
2. Туслах бүтээгдэхүүнээр хангах ДЭМБ-ын 4 үе шаттай танилцах; ДЭМБ-ын тэргэнцрээр хангах 8 үе шат бүхий явцтай харьцуулах
3. Протез, ортоз болон бусад туслах бүтээгдэхүүнтэй ажиллах хүний нөөцийн тухай

### **АРАВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН:**

- ✓ Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай талаарх мэдлэг
- ✓ Туслах бүтээгдэхүүний өргөн цар хүрээ болон тэдгээрийн ач холбогдлын талаарх мэдлэг
- ✓ Үйл ажиллагааны анатоми, био-механик, үений хөдөлгөөний далайц, булчингийн хүч, биеийн байрлал, алхааны талаарх суурь мэдлэг
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцаж амьдрах орчныг нь талаар ойлгох чадвартай байх



- ✓ Хөгжлийн бэрхшээл: мөчдийн тайралт, сколиоз, нугасны гэмтэл, түнхний үений дутуу хөгжил дисплази, майга тавхай.
- ✓ Протез, ортоз, гуталтай холбоотой нэр томъёоны тухай

### **Сертификат олгох**

Оролцогчид сертификат авах болно

- Хичээлийн ирц бүрэн эсвэл албан ёсны чөлөө авсан (ирцийн хуудас)
- Оролцогч хэлэлцүүлэг, дадлага, асуулт хариултад идэвхтэй оролцсон байх

### **Сургалтын үнэлгээ**

- Сургалтын өмнөх ба дараах сорил
- Оролцогчдын үнэлгээний хуудас
- Багш нарын саналын хуудас

### **АРВАН НЭГ. СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ**

Зохион байгуулагчид сургалтын тайланг бэлтгэж, сургалт дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор ХНХЯ болон ажлын хэсэгт хүргүүлэх үүрэгтэй. Сургалтын тайланг дараах иж бүрдэлтэйгээр төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлнэ.

- Сургалтын талаар товч дүгнэлт
- Сургалтын өмнөх болон дараах сорил, сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээний хуудас, түүний үр дүнгийн дүн шинжилгээ, нэгтгэл
- Сургалтад оролцогчдоор гарын үсэг зурж баталгаажуулсан ирцийн бүртгэл
- Багш, туслах ажилтны цагийн тооцоо

-----o0o-----